



ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А1107

Улаанбаатар хот

Эрчим хүчний ажилтны баярын  
өдрийг тэмдэглэх тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын хавсралт "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийн жагсаалт"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам"-ын 2.2, 2.3 дахь заалт, 2019 оны бизнес төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний ажилтны баярын өдрийг 2019 оны 08 дугаар сарын 17-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Баярын арга хэмжээний бэлтгэл ажил хангах, тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тус арга хэмжээнд зарцуулагдах 14080000 /Арван дөрвөн сая наян мянга/ төгрөгийг нийгмийн арга хэмжээний зардлаас тооцохыг Санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Б.Даваадулам/-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс /Б.Гоёцэцэг/-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.БЯМБААХҮҮ

Tushaal.A4.2019

369098301